БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН САНДАГИЙН БЯМБАЦОГТ

2026 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

ЦАХИМ ЗАЛИЛАНГААС СЭРГИЙЛЭХ, ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага

Цахим залилангаас сэргийлэх, хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслөөр санхүү, харилцаа холбоо, цахим үйлчилгээний хүрээнд залилангийн эрсдэлийг бууруулах, хохирол нэмэгдэхээс шуурхай хамгаалах, алдагдсан хөрөнгийг буцаан авах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх харилцан уялдаатай зохицуулалтыг бүрдүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтаар өмчлөх эрхийг, 12 дахь заалтаар төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийг, 14 дэх заалтаар шүүхэд гомдол гаргах, хууль бусаар учруулсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг тус тус баталгаажуулсан. Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан төрийн үүрэг нь цахим үйлчилгээний явцад эдгээр эрх зөрчигдөхөөс хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх бодит баталгааг бүрдүүлэхэд мөн хамаарна. Үүний зэрэгцээ хувийн мэдээлэл, харилцааны нууц, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хамгаалсан Үндсэн хуулийн баталгааг хангана.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд залилах гэмт хэргийг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар гэмт хэргийг шалгах, хөрөнгийг хамгаалах болон хохирол барагдуулахтай холбоотой ажиллагааг зохицуулж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь урьдчилан сэргийлэх ажлын нийтлэг тогтолцоо, зохион байгуулалтын үндсийг тогтоодог. Эдгээр зохицуулалтыг цахим залилангийн эрсдэл илэрсэн даруйд үйлчилгээ үзүүлэгчдийн авах арга хэмжээ, мэдээлэл солилцоо, хохирогчид үзүүлэх туслалцаатай холбож нарийвчлах шаардлагатай.

Банкны тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар банкны нууц, төлбөрийн үйлчилгээний найдвартай байдал, төлбөрийн эцэслэлт, шилжүүлгийн гүйцэтгэл, үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагыг зохицуулдаг. Харин хэрэглэгч хууртагдан шилжүүлгийг зөвшөөрсөн, хөрөнгө хэд хэдэн байгууллагаар дамжсан тохиолдолд эрсдэлийн мэдээллийг нэн даруй дамжуулах, хүлээн авагч талд хөрөнгийг хамгаалах, буцаан олгох шаардлагыг хамтран шалгах нийтлэг ажиллагааг тодорхой болгох хэрэгцээ байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд хүлээгдэж байгаа гүйлгээг тодорхой үндэслэлээр түдгэлзүүлэх эрхийг Санхүүгийн мэдээллийн албаны даргад олгосон. Энэ ажиллагаа нь өөрийн зорилго, үндэслэл, хугацаатай тул цахим залилангийн бүх тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх шуурхай хамгаалалтыг орлохгүй байгаа. Иймээс эдгээр ажиллагааны зааг, мэдээлэх үүрэг, эрх бүхий байгууллагад шилжүүлэх дарааллыг уялдуулан тогтооно.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Харилцаа холбооны тухай, Зар сурталчилгааны тухай хуулиар мэдээллийн аюулгүй байдал, үйлчилгээний нууцлал, хэрэглэгчийн бүртгэл, зар сурталчилгаанд тавих шаардлагыг тогтоосон. Эдгээр суурь шаардлагад тулгуурлан хуурамч дуудлага, зурвас, цахим хаяг, зар сурталчилгаа болон санхүүгийн гүйлгээний хооронд үүсдэг эрсдэлийг хамтран илрүүлэх, таслан зогсоох үүргийг нэг мөр болгоно.

Гүйлгээ, хөрөнгө, холбооны үйлчилгээ, цахим агуулгад хязгаарлалт тогтоох, банкны болон хувийн мэдээлэл дамжуулах нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөнддөг. Иймээс арга хэмжээний үндэслэл, эрх бүхий этгээд, хамрах хүрээ, дээд хугацаа, хяналт, гомдол гаргах баталгааг хуулиар тогтоох шаардлагатай.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Цахим орчинд үйлдэгдсэн залилангийн бүртгэгдсэн хэрэг 2020 онд 1,280 байсан бол 2025 онд 12,233 болж, ойролцоогоор 9.6 дахин өссөн байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувь нь мөн хугацаанд 5.5 хувиас 25.8 хувьд хүрчээ.

2025 онд цахим залилангийн улмаас 77.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, 29.7 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Энэ нь бүртгэгдсэн хэргийн мэдээлэл бөгөөд мэдээлэгдээгүй бүх тохиолдлыг илэрхийлэхгүй юм. Эдгээр нөхцөл байдал нь хохирол учирсны дараах нөхөн төлүүлэлтээс гадна хөрөнгө цааш шилжихээс өмнө хамгаалах ажиллагааг сайжруулах шаардлагыг харуулж байна.

Цахим залилангийн үед хуурамч зар сурталчилгаа, бусдын нэрээр харилцах, данс болон цахим хаягийн эрхийг булаах, хууртагдан шилжүүлэг хийхэд хүргэх зэрэг үйлдэл өөр өөр үйлчилгээний орчинд дараалан явагддаг. Нэг байгууллагад байгаа мэдээлэл нь нөгөө байгууллагын эрсдэлийг танихад шаардлагатай боловч мэдээлэл солилцох эрх зүйн үндэслэл, хүлээн авагч, хариу өгөх хугацаа тодорхойгүй бол хөрөнгө цааш шилжих эрсдэл нэмэгдэнэ.

Иймд хохирогч мэдээллээ шуурхай өгөх, анхны мэдээллийг авсан үйлчилгээ үзүүлэгч хамгаалах ажиллагааг эхлүүлэх, дараагийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээллийг дамжуулах, хохирогч хүсэлтийн явцаа мэдэх нэгдсэн дарааллыг тогтооно. Эрүүгийн хэрэг үүсгэсэн, эсхүл хохирогчоор тогтоосон шийдвэр гараагүй гэх шалтгаанаар мэдээлэл хүлээн авах, эрсдэлийг шалгах, хохирол нэмэгдэхээс хамгаалах ажиллагааг хойшлуулахгүй байх зарчмыг баримтална.

Хууль зүйн хамгаалалт нь залиланд өртсөн этгээдээс гадна дансаа буруу хязгаарлуулсан хүн, хууль ёсны худалдаа, үйлчилгээ эрхлэгч, мэдээллийн эзний эрхийг хамарна. Хуурамч мэдээлэл, алдаатай эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хөрөнгө, үйлчилгээг үндэслэлгүй хязгаарлахаас сэргийлж, шийдвэрийг түргэн хянуулах, алдааг залруулах, учирсан хохирлыг шаардах боломжийг баталгаажуулна.

1.3. Зохицуулалтын хувилбар ба олон улсын туршлага

Сургалт, сэрэмжлүүлгийг нэмэгдүүлэх, байгууллагууд сайн дурын үндсэн дээр хамтран ажиллах арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагатай. Гэвч эдгээр арга хэмжээ нь мэдээлэл дамжуулах эрх зүйн үндэслэл, эрх хязгаарлах нөхцөл, үйлчилгээ үзүүлэгчийн заавал биелүүлэх үүрэг, хохирол нөхөн төлөх хариуцлагыг дангаараа тогтоох боломжгүй. Зөвхөн нэг салбарын хуульд өөрчлөлт оруулах нь бусад салбарт дамжсан эрсдэлийн хариу арга хэмжээг бүрэн хамрахгүй тул салбар хоорондын ажиллагааг нэгтгэсэн анхдагч хуулийн төсөл, түүнийг дагалдах холбогдох бусад хуулийн нэмэлт, өөрчлөлтийг багцлан боловсруулна.

Харьцуулсан судалгаанд зарим улсын залилангаас сэргийлэх хууль санхүү, харилцаа холбоо, цахим үйлчилгээний үүргийг хамтад нь тогтоосон, Бүгд Найрамдах Солонгос Улсын тусгай хууль залиланд ашигласан дансны хөрөнгийг хамгаалж, буцаан олгох ажиллагааг нарийвчилсан туршлага тусгагдсан. Эдгээрээс салбар хоорондын хамтын ажиллагаа, баримт хадгалалт, буцаан олголтын дарааллыг Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн ашиглана.

Австралийн 2025 оны зохицуулалт үйлчилгээ үзүүлэгчдийн урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, мэдээлэх, хариу арга хэмжээ авах үүргийг уялдуулсан бол Их Британийн тогтолцоо нь хамрах нөхцөл, үл хамаарах тохиолдол бүхий хууртагдан зөвшөөрсөн шилжүүлгийн нөхөн төлбөрийн тусгай загвар юм. Хуулийн төсөлд хамгаалсан хөрөнгийг буцаах ажиллагаа болон үйлчилгээ үзүүлэгч үүргээ зөрчсөнөөс үүсэх нөхөн төлбөрийн хариуцлагыг ялган зохицуулна.

1.4. Хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.2-т заасан эрхийн хүрээнд санаачлан боловсруулна. Төсөл нь цахим залилангаас сэргийлэх салбар хоорондын үүрэг, шуурхай хамгаалалт, хохирогчийн эрхийг хангах тусгай зохицуулалттай байна. Гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүн, ялыг энэ хуулиар шинээр тогтоохгүй.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Зорилго, хамрах хүрээ

Хуулийн зорилго нь цахим орчин, харилцаа холбооны сүлжээг ашигласан залилангаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг илрүүлэх, хохирол учрах, нэмэгдэхээс шуурхай хамгаалах, хөрөнгө буцаан олгох, хохирол нөхөн төлүүлэх, хохирогчид туслалцаа үзүүлэх харилцааг зохицуулж, хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Хуулийн үйлчлэлд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлдэг, эсхүл Монгол Улсад байгаа хэрэглэгчид үйлчилгээгээ чиглүүлэн санал болгодог санхүүгийн, харилцаа холбооны, цахим болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг хамруулна. Гадаадын үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлагыг Монгол Улстай бодит холбоотой үйл ажиллагаа, өөрийн хяналтад байгаа үйлчилгээний хүрээнд тодорхойлно.

Хэрэглэгчийн зөвшөөрөлгүй хийгдсэн гүйлгээ болон хууртагдан өөрөө зөвшөөрсөн шилжүүлгийг ялгаж, аль алинд нь шуурхай хамгаалалт үзүүлэх

нөхцөлийг тогтооно. Бараа, ажил, үйлчилгээний үнэ, чанар, хүргэлтийн талаар үүссэн ердийн гэрээний маргааныг цахим залилангийн асуудлаас ялгаж тодорхойлно. Харин худалдаа, үйлчилгээний хэлбэр ашигласан залилангийн шинжтэй үйлдлийг зөвхөн гэрээ байгуулсан гэх шалтгаанаар хуулийн үйлчлэлээс хасахгүй.

2.2. Зохицуулалтын үндсэн чиглэл

Хуулийн төслийг боловсруулахдаа дараах чиглэлийг баримтална:

1. Эрсдэлийг хамгийн түрүүнд илрүүлэх, бууруулах боломжтой үйлчилгээ үзүүлэгчид тухайн боломж, хяналтын хүрээнд нь тодорхой үүрэг хүлээлгэх; хэрэглэгчийг таних, эрсдэлийг шалгах, анхааруулах, мэдээлэх, хамгаалах, баримт хадгалах ажиллагааг уялдуулах.

2. Мэдээлэл, хүсэлт болон заавал биелүүлэх шийдвэрийг ялгаж, арга хэмжээ бүрийн шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч, хянагчийг хуулиар тодорхойлох.

3. Түр хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай гүйлгээ, хөрөнгийн дүн, дугаар, цахим хаяг, агуулгаар хязгаарлаж, хугацаа дууссан, үндэслэл арилсан даруйд цуцлах.

4. Мэдээлэл солилцоог хууль ёсны зорилго, зайлшгүй хэрэгцээнд нийцүүлж, хандалт, дамжуулалтыг бүртгэх;

5. Хохирогч өөрийн мэдэж байгаа мэдээллээр хүсэлт гаргах, өөрт хамаарах баримт, шийдвэрийг авах, үйлчилгээ үзүүлэгчид гаргасан гомдлоо үнэ төлбөргүй шийдвэрлүүлэх боломжийг хангах; үйлчилгээ үзүүлэгч өөрт байгаа баримтыг хэрэглэгчээс давтан шаардахгүй байх.

6. Хөрөнгө буцаан олголт, үйлчилгээ үзүүлэгчийн нөхөн төлбөр, гэмт хэрэг үйлдсэн этгээдээс гаргуулах хохирлыг тус тусын үндэслэлээр шийдвэрлэж, нэг хохирлыг давхар төлөхөөс сэргийлэх; хууль ёсны бусад өмчлөгч, шаардах эрхтэй этгээдийн эрхийг хамгаалах.

2.3. Хуулийн төслийн ерөнхий бүтэц

Хуулийн төслийг анхдагч хуулийн төсөл хэлбэрээр, дараах 11 бүлэгтэйгээр боловсруулна.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэлийг тусгаж, хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томьёо, баримтлах зарчмыг тодорхойлно. Урьдчилан сэргийлэх ажиллагааны хүрээнд хэрэглэх “цахим залилан”, “хохирогч” гэсэн ойлголтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гэм буруу, оролцогчийн эрх зүйн байдлаас ялгана.

Хоёрдугаар бүлэгт урьдчилан сэргийлэх тогтолцоо, байгууллагуудын чиг үүргийг зохицуулна. Засгийн газар хэрэгжилтийг зохион байгуулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбар хоорондын уялдааг хангана. Цагдаагийн төв байгууллагын шуурхай арга хэмжээний нэгж мэдээлэл хүлээн авах, дамжуулах, ажиллагааг уялдуулах чиг үүрэгтэй байна. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо тус тусын харьяаллын дагуу хяналт тавьж, Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус хяналтыг хангана. Хил дамнасан хамтын ажиллагааг Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд нийцүүлнэ.

Гуравдугаар бүлэгт цахим залилангийн мэдээллийн нэгдсэн сан, шуурхай суваг, мэдээлэл солилцох ажиллагааг зохицуулна. Мэдээллийн төрөл, ашиглах

зорилго, эрх бүхий хүлээн авагч, бүртгэл, хадгалалт, залруулга, аюулгүй байдлын шаардлагыг тогтооно. Эрсдэлийн дохио болон шалгалтаар тогтоогдсон мэдээллийг ялгаж бүртгэнэ. Программ хангамжийн үнэлгээг дангаар нь эрх хязгаарлах, хөрөнгө буцаах, нөхөн төлбөр олгохоос эцэслэн татгалзах үндэслэл болгохгүй бөгөөд тайлбар авах, хүнээр дахин хянуулах эрхийг баталгаажуулна.

Дөрөвдүгээр бүлэгт хохирогчийн хөрөнгийг шуурхай хамгаалах, буцаан олгох ажиллагааг зохицуулна. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий ажилтан тодорхой баримт, бодит эрсдэлд үндэслэн гүйцэтгээгүй гүйлгээг түр саатуулах, хүлээн авсан хөрөнгийн зарцуулалтыг тодорхой цагаас илүүгүй хугацаагаар түр хязгаарлах шийдвэр гаргана.

Тавдугаар бүлэгт үйлчилгээ үзүүлэгчийн нийтлэг үүргийг тусгана. Эрсдэлийн үнэлгээ, дотоод хяналт, хариуцсан ажилтан, хэрэглэгчийн баталгаажуулалт, тодорхой анхааруулга, хоногийн 24 цагийн мэдээлэл хүлээн авах суваг, шуурхай хариу арга хэмжээ, баримт хадгалалт, тайлагналын шаардлага тогтооно.

Зургаадугаар бүлэгт санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай үүргийг зохицуулна. Данс, төлбөрийн хэрэгслийн аюулгүй байдал, эрсдэл өндөртэй гүйлгээний нэмэлт баталгаажуулалт, гүйлгээ хийхийн өмнөх анхааруулга, бодит цагийн хяналт, мөнгө дамжуулахад ашигласан дансны эрсдэлийг шалгах, илгээгч болон хүлээн авагч талын хамтын ажиллагааг тусгана.

Долоодугаар бүлэгт харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг зохицуулна. Хэрэглэгчийн бүртгэл, таних модуль солих болон дугаар шилжүүлэх үеийн баталгаажуулалт, дуудлагын дугаар, зурвас илгээгчийн нэрийг хуурамчаар ашиглахаас сэргийлэх, эрсдэлийн дохио солилцох шаардлагыг тусгана.

Наймдугаар бүлэгт цахим үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг зохицуулна. Бусдын нэр, дүр төрх, хиймлээр үүсгэсэн дүрс, дуу хоолой ашигласан залилан, цахим хаяг булаах эрсдэлийг шалгах; зар сурталчилгаа захиалагч, төлбөр төлөгч, худалдаа эрхлэгчийг баталгаажуулах; санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын зарын зөвшөөрөл, бүртгэлийг тулгах шаардлага тогтооно.

Есдүгээр бүлэгт гомдол шийдвэрлэх, хохирол нөхөн төлөх ажиллагааг зохицуулна. Гомдлыг анхны шийдвэр гаргахад оролцоогүй этгээдээр хянуулах, үргэлжилж байгаа түр хязгаарлалтын гомдлыг шуурхай шийдвэрлэх, ердийн гомдолд үндэслэл бүхий хариу өгөх хугацааг тогтооно.

Аравдугаар бүлэгт олон нийтийн боловсрол, хохирогчид үзүүлэх туслалцааг тусгана. Зорилтот бүлэгт тохирсон сургалт, мэдээлэл, хүртээмжтэй үйлчилгээ, баримт хадгалах болон хүсэлт гаргах туслалцаа, нэвтрэх эрхийг сэргээх, дахин хохирохоос хамгаалах арга хэмжээг уялдуулна.

Арван нэгдүгээр бүлэгт хэрэгжилтийн тайлан, зөрчил арилгуулах арга хэмжээ, албан тушаалтан болон үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага, хууль ёсны ажиллагааны хамгаалалт, дагаж мөрдөх хугацаа, шилжилтийн зохицуулалтыг тусгана.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсэж болох үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээ

3.1. Нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хууль батлагдсанаар цахим залилангийн эрсдэлийн мэдээллийг шуурхай хүргэх, хөрөнгө цааш шилжихээс хамгаалах, үйлчилгээ үзүүлэгчдийн үүрэг, хариуцлагыг

тогтоох нөхцөл бүрдэнэ. Хохирогч хаана мэдээлэх, ямар хамгаалалт хүсэх, хөрөнгө буцаах болон нөхөн төлбөрийн шаардлагаа хэрхэн гаргах нь тодорхой болж, байгууллага хооронд давтан хандах хүндрэл буурах боломжтой.

Үйлчилгээ үзүүлэгчид эрсдэлийн хяналт, хэрэглэгчийн баталгаажуулалт, мэдээлэл солилцооны холболт, хоногийн 24 цагийн ажиллагаа, ажилтны сургалт, гомдол шийдвэрлэлт, мэдээллийн хамгаалалтад илүү анхаарал тавьж, эх үүсвэр гаргах шаардлагатай. Төрийн байгууллагад шуурхай нэгжийн ажиллагаа, мэдээллийн сан, аюулгүй холболт, хяналт, судалгаа, хүртээмжтэй сургалтын чиглэлээр арга хэмжээ, эх үүсвэрийн хэрэгцээ бий.

Хэрэгжилтийн явцад хууль ёсны гүйлгээ саатах, данс, цахим хаягийг алдаатай хязгаарлах зарим эрсдэл бий. Иймд арга хэмжээг эрсдэлд тохируулан хэрэглэх, нэгдсэн техникийн шаардлага тогтоох, давхардсан тайлагналыг бууруулах, шийдвэрийг хүнээр хянуулах, шуурхай гомдол шийдвэрлэх болон зөрчигдсөн эрхийг сэргээх хамгаалалтыг хамтад нь хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгана.

Үйлчилгээ үзүүлэгчийн нөхөн төлбөр нь хуульд заасан үүргийн зөрчил, хохирол, шалтгаант холбоонд үндэслэнэ.

3.2. Хэрэгжилтийг хангах арга хэмжээ

Хууль хэрэгжиж эхлэхээс өмнө салбар хоорондын мэдээлэл солилцоог турших, нөөц суваг ажиллуулах, шийдвэрийн баталгаажуулалт, хандалтын эрх, хугацааны хяналтыг бэлтгэх, ажилтнуудыг сургах, хэрэглэгчид мэдээлэл хүргэх ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Хуулийн төслийн 2027 оны 7 дугаар сарын 1-нээс дагаж мөрдөх саналыг бэлтгэл ажлын хугацаа, зардлын тооцоо, байгууллагуудын бэлэн байдлын үнэлгээтэй тулган эцэслэнэ.

Хэрэгжилтийг хүлээн авсан мэдээллийн тоо, арга хэмжээ авахад зарцуулсан хугацаа, хамгаалсан болон буцаан олгосон хөрөнгө, төлсөн нөхөн төлбөр, алдаатай хязгаарлалт, эрх сэргээсэн хугацаа, гомдлын шийдвэрлэлт, мэдээллийн хамгаалалтын зөрчил зэрэг үзүүлэлтээр үнэлнэ.

Дөрөв. Бусад хууль тогтоомжтой уялдах байдал, дагалдан боловсруулах эрх зүйн актын санал

4.1. Үндсэн хууль, олон улсын гэрээтэй нийцүүлэх

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулна. Өмчлөх эрх, хувийн нууц, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хөндөх арга хэмжээ нь хуульд тодорхой заасан, зорилгодоо тохирсон, зайлшгүй шаардлагатай, боломжит хамгийн бага хүрээтэй байна. Шийдвэрийн үндэслэлийг мэдэх, тайлбар гаргах, хараат бус хяналт болон шүүхийн хамгаалалт авах баталгааг хангана.

Гадаадын байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, хүсэлтийг Монгол Улсад хөрөнгө, үйлчилгээ, цахим агуулгыг хязгаарлах бие даасан үндэслэл болгохгүй. Хил дамнасан мэдээлэл дамжуулалт, баримт хадгалуулах, хөрөнгө хамгаалуулах, буцаан олгуулах ажиллагааг тухайн улстай байгуулсан олон улсын гэрээ болон холбогдох хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ.

4.2. Холбогдох хуультай уялдуулах

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Прокурорын тухай, Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тогтоосон чиг үүрэг, ажиллагааны журмыг баримтална. Үйлчилгээ үзүүлэгчийн түр хамгаалалтаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хөрөнгийн хязгаарлалтад шилжих үндэслэл, мэдээлэл хүргүүлэх хугацаа, эрх бүхий этгээдийн шийдвэрийг тодорхой уялдуулна.

Иргэний хуульд заасан гэрээний үүрэг, үндэслэлгүй хөрөнгөжсөнөөс үүсэх үүрэг, гэм хорын хариуцлагатай хөрөнгө буцаан олголт, нөхөн төлбөрийн зохицуулалтыг нийцүүлнэ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэхэмжлэлийг хангах арга хэмжээ, төлбөрийн дараалал, гүйцэтгэлийн зохицуулалтад нийцүүлнэ. Захиргааны ерөнхий, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны шийдвэрийн хяналтыг, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар талуудын сайн дурын тохиролцоог тус тус хангана.

Төв банк /Монголбанк/-ны тухай, Банкны тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хяналтын харьяалал, нууцлал, гүйлгээний гүйцэтгэлийн шаардлагатай нийцүүлнэ. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Даатгалын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай зэрэг салбарын хуулийн үйлчилгээнд шинэ үүрэг хэрхэн хэрэгжихийг үйлчилгээний онцлогоор тогтооно.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шаардлагыг мэдээллийн сан, шуурхай суваг, үнэлгэ, нээлттэй тайлагналд баримтална.

Харилцаа холбооны тухай, Зар сурталчилгааны тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн баталгааг цахим залилангийн тусгай хамгаалалттай уялдуулна. Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, ахмад настны хамгаалалттай холбоотой хуулийн шаардлагыг мэдээлэл, сургалт, хүсэлт гаргах сувгийн хүртээмжид тусгана.

4.3. Хамт өргөн мэдүүлэх нэмэлт, өөрчлөлтийн чиглэл

Үндсэн зохицуулалтыг шинэ хуульд тогтоож, бусад хуульд дараах хүрээнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хамт боловсруулна:

1. Банкны тухай хуульд цахим залилангийн мэдээллийг эрх бүхий байгууллага, үйлчилгээ үзүүлэгчид зориулалт, хүрээ нь хязгаарлагдсан нөхцөлөөр дамжуулах эрх зүйн үндэслэл, нууцлалын баталгааг уялдуулах хэрэгцээ шаардлага бий эсэх.

2. Үндэсний төлбөрийн системийн тухай болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд гүйцэтгээгүй гүйлгээг хуульд заасан үндэслэлээр түр

саатуулах, хүлээн авсан хөрөнгийг хамгаалах, буцаан олголтыг тусдаа гүйлгээгээр хийх ажиллагааны уялдааг тусгах эсэх.

3. Харилцаа холбооны тухай, Зар сурталчилгааны тухай, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд шинэ хуулийн тусгай үүрэг, мэдээлэл солилцоо, хяналтын харьяаллыг холбоос зохицуулалтаар тодорхойлох шаардлага бий эсэхийг тодруулна.

4. Цагдаагийн албаны тухай болон холбогдох зохицуулах байгууллагын эрх зүйн байдлын хуулиудад шуурхай зохицуулалт, мэдээллийн сан, салбарын хяналтыг хэрэгжүүлэхэд дутуу байгаа бүрэн эрхийг тодорхойлж, шаардлагатай нэмэлтийг тусгах асуудлыг тодруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ